



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
БИЕЙИН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/44

Улаанбаатар хот

Г Албан хаагчдын ажлыг улирал бүр  
дүгнэн мөнгөн урамшуулал олгох  
журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дах заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолын 2.6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 442 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын ажлыг улирал бүр дүгнэн мөнгөн урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Албан хаагчдын ажлыг улирал бүр дүгнэн мөнгөн урамшуулал олгох журмын дагуу хугацаанд нь дүгнэж, дүгнэгдсэн үнэлгээний хувиар мөнгөн урамшуулал олгохыг нягтлан бодогч (Л.Цогцэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. Цаашид хариуцсан ажилдаа улам их амжилт гарган идэвх, санаачлагатай ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА   
Г.БАТБАЯР



ویسوس شتماً مسعودیاً تدم ون ) تدم مسیون ، بکلار فم زیندر )  
سلمنیا تدم هرندیا

فَتَسْأَلُونِي أَنْ أَعْلَمُ بِكُمْ إِنِّي لَكُمْ مِنْ بَعْدٍ عَالِمٌ

ପ୍ରକାଶନ କେନ୍ଦ୍ର

بیوگریتھسکام ۲۰ بیعنی ن ۲۰۰۰ پیش پنجم خدینام

بَعْدَهُمْ يَعْلَمُونَ

卷之三

۴- سوهر ناشنسته مردم هم بستان از بحثیتی پیشید مادرانه را در دارم بگذیرند و بعثتیتی پیشید مادرانه را در دارم بگذیرند ..

٣- عَسْنِيدُمْ بِعَسْتَقَسْسِمْ بَعْدَهُ ٦٩٦ مُعَايِهَ تَحْتَهُ بِعَدِيدُمْ زَنْثَنَرْ بَعْدُونَ .  
شَنْشَنَتْشَنْشَنَدْ بِعَدِيسْسَهَ لَيْ نَبَغِي بِعَوَلَهَ زَنْسَسْسِهَمْ ٦٩٦ بَعْدَهُ شَنْشَنَشَنَشَنَلْ .

مسنونہ حضرت  
دیوبندی

Баянгол дүүргийн Биеийн тамир спортын хорооны  
даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн  
1/4 дугаар тушаалын хавсралт

УОЗ0095

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ АЛБАН ХААГЧДАД  
УЛИРЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР МӨНГӨН УРАМШУУЛАЛ  
ОЛГОХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгоход гол зорилго оршино.
- 1.2. Улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг байгууллагын дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, даргаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ хангалттай гүйцэтгэж, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.
- 1.3. Улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг даргын тушаалаар тухайн байгууллагад томилогдон 6 сараас дээш хугацаанд ажилласан албан хаагчид олгоно.
- 1.4. Улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг Төрийн албаны тухай хуулийн заалт, байгууллагын дотоод журмын 9 дүгээр заалт, энэхүү журмын 2.8, 2.9 дэх заалтыг үндэслэн албан хаагчийн үндсэн цалингаас Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар тогтоолын 2023 оны 12 дугаар сарын 13-ны 442 дугаар тогтоолоор тогтоосон хувь хэмжээгээр улирал бүр тооцож олгоно.

**ХОЁР. УЛИРЛЫН УРАМШУУЛАЛ ОЛГОХОД БАРИМТЛАХ  
ШАЛГУУР, ҮНЭЛГЭЭ**

Албан хаагчид улирлын мөнгөн урамшуулал олгоходоо, байгууллагын онцлог, албан тушаалын чиг үүрэгт тохирсон шалгуурыг баримталж, энэхүү журамд заасан ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийн оноог үндэслэн олгоно.

- 2.1. Албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн ажлын гүйцэтгэл, чанар /40 оноо/
- 2.2. Ажлын цаг ашиглалт /10 оноо/
- 2.3. Албан хэргийн хётлэлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал /15 оноо/
- 2.4. Ажлын идэвх санаачлага, шинээр санаачилсан ажил, олон нийтийн арга а. хэмжээнд оролцсон байдал /15 оноо/

- 2.5. Ёс зүйн байдал /10 оноо/
- 2.6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт /10 оноо/
- 2.7. Үр дүнгийн шалгуурын биелэлт /хувиар/
1. 95-100 оноо –46-50 хувь
  2. 90-94 оноо – 41-45 хувь
  3. 85-89 оноо – 31-40 хувь
  4. 80-84 оноо – 26-30 хувь
  5. 70-79 оноо – 20-25 хувь
- 2.8. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үр дүнг байгууллагын дарга, ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч нар хэлэлцэн улирлын сүүлийн сарын 20-ны дотор дүгнэж, дараа сарын цалинд бодож олгоно.
- 2.9. Улирлын урамшуулал олгох шийдвэрийг даргын тушаалаар олгоно.
- 2.10. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.

